



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/383

Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн Дотоод Аудитын
Албаны эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Чингэлтэй дүүргийн Дотоод Аудитын албаны эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 12,320,600.00 (арван хоёр сая гурван зуун хорин мянга зургаан зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Чингэлтэй дүүргийн Дотоод Аудитын алба (М.Хоролсүрэн)-нд зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 8 нэр төрлийн 4,700,400.00 (дөрвөн сая долоон зуун мянга дөрвөн зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтанд дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 4 нэр төрлийн 7,620,200.00 (долоон сая зургаан зуун хорин мянга хоёр зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 80,000.00 (наян мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 24,000.00 (хорин дөрвөн мянга) төгрөгийг нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Чингэлтэй дүүргийн Дотоод Аудитын алба (М.Хоролсүрэн)-нд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150501152

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 438 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Чингэлтэй дүүргийн дотоод аудитын алба

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл /2024 оны 09-р сарын 27 өдрийн байдал/	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨХГ-ын мэргэжилтний дүгнэлт	ЭБХХХК-н шийдвэр
1	DELL 5379 notebook	6	ш	1	2,394,400.00	2,394,400.00		2,394,400.00	Ашиглалтын хугацаа дуусч үлдэх өртөггүй болсон. Үйлдлийн систем хуучирсан. Шинэчлэлт хийх боломжгүй. Сэлбэг хэрэгсэл олдохгүй болсон. Хүчин чадал нь ачааллаа дийлэхгүй, хэрэглээний программуудыг дэмжихгүй ажлын шаардлага хангахгүй байна	Актлах	устгах	20,000.00	50,000.00
2	Компьютер	11	ш	2	950,000.00	1,900,000.00		1,900,000.00	Ашиглалтын хугацаа дуусч үлдэх өртөггүй болсон. Үйлдлийн систем хуучирсан. Шинэчлэлт хийх боломжгүй. Сэлбэг хэрэгсэл олдохгүй болсон. Хүчин чадал нь ачааллаа дийлэхгүй, хэрэглээний программуудыг дэмжихгүй. Холбогч кабель нь хэт хуучирч гэмтсэн худалдаад байхгүй	Актлах	устгах	10,000.00	10,000.00
3	Агаар цэвэршүүлэгч	7	ш	1	120,100.00	120,100.00		120,100.00	Ашиглалтын хугацаа дууссан Үлдэх өртөггүй Засварлах боломжгүй Тэжээлийн блок шатсан	Актлах	устгах	устгах	устгах
4	Компьютер	10	ш	1	1,009,800.00	1,009,800.00		1,009,800.00	Ашиглалтын хугацаа дуусч үлдэх өртөггүй болсон. Үйлдлийн систем хуучирсан. Шинэчлэлт хийх боломжгүй. Сэлбэг хэрэгсэл олдохгүй болсон. Хүчин чадал нь ачааллаа дийлэхгүй, хэрэглээний программуудыг дэмжихгүй	Актлах	устгах	10,000.00	10,000.00

5	Компьютер DELL	10	ш	2	1,158,000.00	2,316,000.00	2,316,000.00	-	Ашиглалтын хугацаа дуусч үлдэх өртөггүй болсон. Үйлдлийн систем хуучирсан. Шинэчлэлт хийх боломжгүй. Сэлбэг хэрэгсэл олдохгүй болсон. Хүчин чадал нь ачааллаа дийлэхгүй, хэрэглээний программуудыг дэмжихгүй болсон. Техникийн гэмтэл нь тодорхойлгүй.	Актлах	устгах	10,000.00	10,000.00
6	Өнгөт принтер	10	ш	1	412,500.00	412,500.00	412,500.00	-	Ашиглалтын хугацаа дууссан Үлдэх өртөггүй Засварлах боломжгүй. Технологи нь хэт хуучирснаас сэлбэг нь олдохгүй байна. Хэвлэлтийн толгой гэмтсэн тул хэвлэхгүй болсон.	Актлах	устгах	устгах	устгах
7	Камер	10	ш	1	1,320,000.00	1,320,000.00	1,320,000.00	-	Ашиглалтын хугацаа дууссан Үлдэх өртөггүй Засварлах боломжгүй Сэлбэг байхгүй	Актлах	устгах	устгах	устгах
8	Камерийн дуран	10	ш	1	890,000.00	890,000.00	890,000.00	-	Ашиглалтын хугацаа дууссан Үлдэх өртөггүй Линз гэмтсэн	Актлах	устгах	устгах	устгах
9	Өнгөт принтер	7	ш	1	407,000.00	407,000.00	407,000.00	-	Ашиглалтын хугацаа дууссан Үлдэх өртөггүй Засварлах боломжгүй. Технологи нь хэт хуучирснаас сэлбэг нь олдохгүй байна. Хэвлэлтийн толгой гэмтсэн тул хэвлэхгүй болсон.	Актлах	устгах	устгах	устгах
10	HP1132 принтер	10	ш	1	329,900.00	329,900.00	329,900.00	-	Ашиглалтын хугацаа дууссан Үлдэх өртөггүй Засварлах боломжгүй Механик гэмтэлтэй	Актлах	устгах	устгах	устгах
11	Принтер M1132 MFP	10	ш	1	329,900.00	329,900.00	329,900.00	-	Ашиглалтын хугацаа дууссан Үлдэх өртөггүй Засварлах боломжгүй Механик гэмтэлтэй	Актлах	устгах	устгах	устгах
12	Принтер	11	ш	3	297,000.00	891,000.00	891,000.00	-	Ашиглалтын хугацаа дууссан Үлдэх өртөггүй Засварлах боломжгүй сэлбэг хэрэгсэл нь олдохгүй. Хэвлэлтийн араа болон бусад хуванцар эд анги элэгдсэн	Актлах	устгах	устгах	устгах
Тонот төхөөрөмжийн дүн				16		12,320,600.00	12,320,600.00	-				50,000.00	80,000.00
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						12,320,600.00	12,320,600.00						
Үүнээс. Худалдах хөрөнгө						7,620,200.00	7,620,200.00						
Устгах хөрөнгө						4,700,400.00	4,700,400.00						
Татан төвлөрүүлэх хөрөнгө													
Худалдсанаас олох орлого												50,000.00	80,000.00
НӨХГ-г төвлөрүүлэх /30%/												15,000.00	24,000.00